


Эдийн засгийн өсөлт 11% (II улирал)


ДНБ энэ оны эхний хагас жилийн байдлаар 6.2 их наяд төгрөгт (4.5 тэрбум ам.доллар) хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 25%, харин 2005 оны зэрэгцүүлэх үнээр 2.4 их наяд төгрөг (1.7 тэрбум ам.доллар) болж, өнгөрсөн оны мөн үеэс 13% тус тус өссөн байна.

ДНБ-ий улирлын бодит өсөлт 11% хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.8 нэгжээр бага байна.




Төсвийн алдагдал 0.5 их наяд төгрөг

Улсын нэгдсэн төсвийн орлого өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 14% өссөн бол зарлага түүнээс даруй 3 дахин хурдтай буюу 42% өссөн нь төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 483 тэрбум төгрөгийн (0.4 тэрбум ам.доллар) алдагдалтай гарахад хүргэлээ. Орлого нэмэгдэхэд НДШ 53%, НӨАТ 19%, ХАОАТ 49% тус тус өссөн нь нөлөөлжээ. Харин зарлага өсөхөд татаас ба шилжүүлэг 41%, хөрөнгийн зардал 82%, цалингийн зардал 41% өссөн нь нөлөөлөв.



Гадаад худалдааны алдагдал 1.8 тэрбум ам.доллар

Нийт барааны эргэлт энэ оны эхний 8 сарын байдлаар 7.5 тэрбум ам.долларт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7% нэмэгдсэн байна. Экспорт 0.8%, импорт 11% тус тус өссөнөөс гадаад худалдааны алдагдал 1.8 тэрбум ам.долларт хүрлээ. Экспортын өсөлтөд нүүрсний экспорт өмнөх оноос 9%, зэс 16%, төмрийн хүдэр 30%, боловсруулаагүй газрын тос 38% өссөн нь нөлөөлжээ. Импортын өсөлтөд дизель түлш 24%, автобензин 42%, суудлын автомашины импорт 18% өссөн нь голлон нөлөөлөв. Харин ачааны автомашины импорт 20%, шороо чулуу холих, ялгах машины импорт 32% буурчээ.



Төгрөгийн ам.доллартай харьцах ханш эрчимтэй суларч байна

Төгрөгийн ам.доллартай харьцах сарын дундаж ханш өмнөх сарынхаас 1.5%, өнгөрсөн оны мөн үеэс 10.1% тус тус суларлаа. Гадаад валютын нийт албан нөөц 2.7 тэрбум ам.долларт хүрч, өнгөрсөн сарынхаас 1.7% буурсан бол өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 4.5% нэмэгдэв. Төгрөгийн ханш сулрах хандлага улам эрчимжиж байна.



Инфляцын түвшин 14%-иас буухгүй байна

Улсын хэмжээгээр тооцсон жилийн инфляцын түвшин өмнөх сарынхаас 0.4 нэгжээр нэмэгдэж 14.9% хүрээд байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5.9 нэгжээр өндөр байгаа юм.


Үнийн дундаж түвшин өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14.9% нэмэгдэхэд хүнсний барааны үнэ 25%, зочид буудал, зоогийн газрын үйлчилгээний үнэ 25%, түүнчлэн боловсролын үйлчилгээний үнэ 16.5% өссөн нь голлон нөлөөлжээ.



Эх сурвалж: ҮСХ, МБ

Мөнгөний нийлүүлэлт нэмэгдэж байна


M2 мөнгө өмнөх оны мөн үеэс 18.5%, өнгөрсөн сараас 0.6% тус тус нэмэгдэж 6.9 их наяд төгрөгт (5.0 тэрбум ам.доллар) хүрчээ. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө өнгөрсөн оныхоос 15%, өмнөх сарынхаас 2% нэмэгдэж, нийт мөнгөний 11.6%-ийг эзэлж байна. Өмнөх сартай харьцуулахад төгрөгийн хадгаламж бага зэрэг буурах хандлагатай байна.



Төгрөгийн хадгаламж өмнөх сарынхаас буурав

Хадгаламжийн хэмжээ өмнөх оныхтой харьцуулахад 24.2% нэмэгдэж 4.4 их наяд төгрөгт (3.2 тэрбум ам.доллар) хүрлээ.


Төгрөгийн хадгаламж өмнөх оны мөн үеэс 15% өссөн бол валютын хадгаламж 54% өсчээ. Харин өмнөх сарынхтай харьцуулахад төгрөгийн хадгаламж 1.6% буурч, валютын хадгаламж 3.7% нэмэгдсэн үзүүлэлттэй байв. Нийт хадгаламжийн 70 хувийг төгрөгийн хадгаламж бүрдүүлж байна.



Чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэж эхэллээ

Зээлийн өрийн үлдэгдэл өмнөх сарынхаас 3.8%, өнгөрсөн оны мөн үеэс 37.0% нэмэгдэж, 6.7 их наяд төгрөг (4.9 тэрбум ам.доллар) боллоо.

Чанаргүй зээлийн хэмжээ өнгөрсөн оныхоос 17% буурсан бол өмнөх сарынхаас 2.1% нэмэгдэж, нийт зээлд эзлэх хувь 4.7% хүрэв. Зээлийн хүү (жилийн, жигнэсэн дундаж) жилийн өмнөхтэй харьцуулахад төгрөгийнх 1.1, валютынх 1.4 нэгжээр тус тус өсчээ.



Эх сурвалж: ҮСХ, МБ

Сарын онцлох үйл явдал

- > Монголын анхны салхин ферм байгуулах төсөлд зориулж Европын сэргээн босголт, хөгжлийн банк болон Нидерландын санхүүгийн хөгжлийн компани Монгол Улсад 85 сая ам.долларын зээл олгохоор болов.
- > Засгийн газрын хуралдаанаар дизель түлшний импортын тонн тутамд 109 мянган төгрөгийн онцгой албан татвар ногдуулахаар шийдвэрлэлээ.
- > "Шинэчлэлийн төлөө түншлэл" форумын үеэр "Өрсөлдөх чадвар, бизнесийн орчныг сайжруулах замын зураглал"- ыг хувийн хэвшлийнхэн Засгийн газарт өргөн барилаа.

Хураангуй

Хятадын эдийн засгийн өсөлт буурсан нь манай эдийн засагт нөлөөлж эхлэв. Монгол Улсын экспортын 90%-ийг дангаараа хангадаг Хятадын үйлдвэрүүдийн нүүрсний худалдан авалт багассанаас экспорт, татварын орлого буурч улмаар улсын төсвийн орлого тасалдахад хүрээд байна.

VII сард нүүрсний борлуулалт өмнөх сард 71%, зэсийнх 18% унаад байсан бол энэ сард бага зэрэг сэргэж байна. Он гарсаар бид сард дунджаар 1.7 сая тонн нүүрс экспортолж байсан бол VII сард 0.9 сая тонн, VIII сард 1 сая тонныг экспортолжээ. Сард 180 орчим сая ам.долларын орлого нүүрсний борлуулалтаас олж байсан бол сүүлийн 2 сарын байдлаар 2 дахин буурлаа.

Түүнчлэн экспортын орлого, гадаадын хөрөнгө оруулалт татарснаас валютын нийлүүлэлт буурч төгрөгийн ам.доллартай харьцах ханш эрчимтэй суларч байна. Сарын дундаж ханш өмнөх сарынхаас 20 төгрөгөөр суларсан бөгөөд VIII сарын эцэст 1382 төгрөг, IX сарын эхний хагаст 1400 төгрөгт хүрэв.

Ийм нөхцөл байдалд инфляц буурахгүй нь тодорхой. Энэ сард хэрэглээний барааны дундаж үнэ өнгөрсөн оны мөн үеэс 14.9% нэмэгджээ. Үүнд хүнс, түүнийг дагаад зочид буудал зоогийн газрын үйлчилгээний үнэ, дээрээс нь боловсролын үйлчилгээний үнэ өссөн нь голлон нөлөөлжээ.

Банкууд зээлээ хумиж, зээлийн өсөлт саарч байгаа бөгөөд сүүлийн жил гаруйн хугацаанд тасралтгүй буурч ирсэн чанаргүй зээлийн хэмжээ энэ сард өмнөх сарынхаас 2.1% нэмэгдэв. Өөрөөр хэлбэл зээлжих чадвар болоод зээлийн чанар аль аль нь буурч байна.

Бид уул уурхайн салбарт олборлох бус боловсруулах бодлого баримтлах, түүний хажуугаар уул уурхайгаас орж ирж буй мөнгөө тараах бус өсгөдөг систем рүү шилжих хэрэгтэй. 2008 онд Хятадын эдийн засаг харьцангуй сайн байсан нь бид хямралыг хөнгөн давахад хүргэсэн ч одоо байдал өөр байна.